

**“ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
НӨХЦӨЛ, ШААРДЛАГА (ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)”-Д
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 143 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Интернэтийн үйлчилгээнд)”-д дараах агуулга бүхий 4 дүгээр зүйлийн 4.7, 5 дугаар зүйлийн 5.7, 5.8 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ “4.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийг өөрийн үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөмжөөр хангана.”

2/ “5.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Интернэтийн чанарт тавих шаардлага” MNS 6966:2026 Монгол Улсын стандартыг мөрдөнө.

5.8. Зохицуулах хороо нь интернэтийн үйлчилгээний чанарын шаардлагын хэрэгжилтийг хараат бус хэмжилт хийх, мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн тайланд үндэслэн дүн шинжилгээ хийх замаар үнэлнэ.”

2. Энэхүү нөхцөл, шаардлагын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ “4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний нөхцөл, шаардлага, гэрээ, үйлчилгээний чанарын талаарх мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой хэлбэрээр боловсруулж, өөрийн цахим хуудас болон боломжит бусад сувгуудаар нийтэд мэдээлнэ.”

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА
(ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн интернэтийн үйлчилгээ (цаашид “интернэтийн үйлчилгээ¹” гэх) эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтооно.

**ХОЁР. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИХ НИЙТЛЭГ НӨХЦӨЛ,
ШААРДЛАГА**

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлагын 4.2-т заасны дагуу улс хоорондын сүлжээ байгуулж, интернэтийн бөөний урсгал нийлүүлэх үйлчилгээ эрхлэх эрх бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сүлжээнд “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын дагуу холбогдож, интернэтийн урсгал түрээслэнэ.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний чанарыг сайжруулах, сүлжээ болон үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор интернэтийн дундын холболтын төвтэй 2-р түвшинд² холболт үүсгэнэ.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн дундын холболтын төвөөр дамжиж буй хэрэглэгчийн урсгалд ямар нэгэн хязгаарлалт хийхгүй.

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан үндэслэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу Зохицуулах хорооноос зарласан Монгол Улсын хууль зөрчсөн домэйн нэр, серверийн АйПи³ хаягийг технологийн боломжийг харгалзан өөрийн сүлжээнд хязгаарлана.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусдын дуу, дүрс дамжуулалттай холбоотой үйлчилгээг дамжуулахдаа хуульд зааснаас бусад тохиолдолд интернэт хурдны болон бусад хязгаарлалт хийхгүй.

2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний нөхцөл, шаардлагын 4.1 дэх заалтын дагуу сүлжээний үйлчилгээ эрхлэх зорилгоор харилцаа холбооны сүлжээ байгуулахгүй, харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түрээслэнэ. Сүлжээ байгуулах тохиолдолд зөвхөн өөрийн үйлчилгээгээ хүргэх зорилгоор хот суурин газрын сүлжээ байгуулж болно.

2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн үйлчилгээний үнэ тарифаа Зохицуулах хорооноос баталсан аргачлалын дагуу тогтоож, олон нийтэд ил тод мэдээлнэ.

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

¹ Интернэтийн үйлчилгээ гэж утастай, утасгүй (WiFi, mobile radio access гм) болон хиймэл дагуулын технологиор хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно.

² Layer 2 of the OSI network model

³ IP – internet protocol

3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шугам, сүлжээтэй холбоотой дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.1.1.техникийн өрөө нь тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйлчилгээнд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийн техникийн нөхцөлд заагдсан орчны шаардлага, үндэсний стандарт, олон улсын стандарт болон Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын 4.4 дэхь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх;

3.1.2.үндсэн техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахилгааны хоёроос доошгүй эх үүсвэрт холбогдсон байх бөгөөд нөөц зай тэжээлийн эх үүсвэрийг зохион байгуулсан байх;

3.1.3.улс хоорондын сүлжээ байгуулж, интернэтийн бөөний урсгал нийлүүлэх эрх бүхий этгээдтэй холбогдож байгаа үндсэн замчлагч төхөөрөмж⁴ нь хэрэглэгчийн интернэтийн үйлчилгээний чанарт тавигдах үндэсний болон олон улсын стандарт, шаардлагыг⁵ хангахуйц холболттой байх;

3.1.4.Зохицуулах хорооноос зохион байгуулсан сүлжээний цагийн нэгдсэн серверээр дамжуулан Монгол Улсын эталон цагтай холбогдож, эталон цагийг ашиглах;

3.1.5.домэйн нэрийн системүүд⁶ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмжүүдэд⁷ www.black-list.mn домэйн нэрд харгалзах АйПи хаягаас ирэх домэйн нэрийн асуулга хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлэх;

3.1.6.интернэт урсгалын ачааллыг үйлчилгээний төрлөөр ангилах боломжийг бүрдүүлэх⁸ сервертэй байх бөгөөд холбогдох мэдээллээр Зохицуулах хороог хангаж ажиллах;

3.1.7.техник, тоног төхөөрөмж шинээр суурилуулах, өргөтгөх, шилжүүлэх, технологийн шинэчлэл хийхдээ Зохицуулах хороо болон хэрэглэгчдэд урьдчилан мэдээлэх.

3.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн үйлчилгээний тасалдалгүй, найдвартай ажиллагаатай холбоотой дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.2.1.сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн систем, өөрийн үйлчилгээ хүргэж буй сүлжээний топологийг бүрэн хамруулсан програм хангамжтай байх;

3.2.2.үндсэн болон нөөц техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг тогтмол хугацаанд хэмжих, шалгах, тухайн техник, тоног төхөөрөмжийн гадна талд тэмдэглэгээ хийж, бүртгэл хөтлөх;

3.2.3.техникийн үзлэг, хэмжилт хийх, гэмтэл саатлын үед ажиллах журамтай байх;

3.2.4.хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сарын хугацаагаанд хадгалах;

3.2.5.үндсэн серверүүд (домэйн нэр⁹, төлбөр тооцоо, танин баталгаажуулж холболт хийх¹⁰ гэх мэт)-ийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллах ба кибер халдлагын талаарх мэдээллийг хагас жил тутам Зохицуулах хороо болон Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвд ирүүлэх;

3.2.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу насанд хүрэгчдэд зориулсан контент (+18)-д хандах хандалтыг хязгаарлах системийн эсвэл програм хангамжийн үйлчилгээтэй байна. Энэхүү үйлчилгээг хэрэглэгчийн гэрээ болон өөрийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд санал болгож мэдээлдэг байх.

⁴ router

⁵ QoE- quality of experience

⁶ Domain name systems

⁷ Firewall

⁸ коллектор сервер буюу системүүдийн лог хадгалах

⁹ Domain name system

¹⁰ PPPoE - Point-to-Point Protocol over Ethernet

3.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн сүлжээний хаягжилт, түүний зохион байгуулалттай холбоотой дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1.АйПи хаягийн 4 болон 6-р хувилбарыг хослуулан ашиглах¹¹ техникийн боломжийг бүрдүүлсэн байна. Хэрэглэгчийн төхөөрөмжийг АйПи хаягийн 6 дугаар хувилбарыг дэмжин ажилладаг төхөөрөмжөөр шинэчлэх ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

3.3.2.интернэтийн үйлчилгээнд гадаад АйПи (IPv4) хаягийг хамгийн ихдээ 20 хэрэглэгчийн дунд нэг байхаар зохион байгуулах;

3.3.3.интернэтийн үйлчилгээнд гадаад АйПи хаягийн 4 болон 6-р хувилбарыг хослуулан ашиглах Дуал Стэк технологийг нэвтрүүлсэн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд нэг гадаад АйПи хаягийг хамгийн ихдээ 100 хэрэглэгчийн дунд нэг байхаар зохион байгуулж болно;

3.3.4.хэрэглэгчийн интернэт үйлчилгээнд АйПи хаягийн хувиргалт¹² ашиглах тохиолдолд хэрэглэгчийн нэг удаагийн холболт дахь бүх хандалт нэг гадаад АйПи хаягаар дамжсан байх боломжийг бүрдүүлэх бөгөөд харгалзах /гадаад, дотоод/ хаягуудын мэдээллийг нэг жилийн хугацаанд хадгалах;

3.3.5.Интернэтийн порт (TCP,UDP)-ыг интернэтийн дугаар олгох байгууллага¹³-с албан ёсоор тогтоон хуваарилсан жагсаалтыг баримтлан нээлттэй байлгах.

3.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос шаардсаны дагуу өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх сүлжээний бүтэц, бусад сүлжээ, системтэй холбогдсон байдал, техникийн үзүүлэлт, интернэт сүлжээний серверийн холболт, хаягжилтын талаарх дараах мэдээллийг жилд нэг удаа ирүүлнэ. Үүнд:

3.4.1.Сүлжээний бүтцийн зураглал;

3.4.2.Системийн мэдээлэл, техникийн үзүүлэлт;

3.4.3.Бусад сүлжээ, системтэй холбогдсон байдал, техникийн үзүүлэлт;

3.4.4.АПНИК (APNIC)-ээс авсан АйПи (IP) хаягийн блок болон ЭйЭс (AS) дугаар;

3.4.5.Үндсэн (DNS) домэйн нэрийн серверийн IP хаяг;

3.4.6.Эталон цагт холбогдсон байдал;

3.4.7.Кэйш (cache) серверүүдийн ашиглалтын мэдээлэл (тоо, зориулалт);

3.4.8.Бусад үйлчилгээ эрхлэгчидтэй хийсэн шууд холболтын (Peer-to-peer) мэдээлэл.

3.5.Хэрэглэгчийг интернэт сүлжээнд хиймэл дагуулын технологиор холбох тохиолдолд энэхүү нөхцөл, шаардлагын 3.4.4, 3.4.6, 3.4.7, 5.2, 5.6 дахь заалтууд, утасгүй технологиор¹⁴ холбох тохиолдолд энэхүү нөхцөл шаардлагын 3.3.2, 3.3.3, 3.3.4, 5.2 дахь заалтууд тус тус хамаарахгүй.

ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА

4.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний нөхцөл, шаардлага, гэрээ, **үйлчилгээний чанарын** талаарх мэдээллийг **үнэн зөв**, ойлгомжтой хэлбэрээр боловсруулж, өөрийн цахим хуудас болон боломжит бусад сувгуудаар **нийтэд** мэдээлнэ.

4.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үндэсний болон олон улсын стандарт, баталгаажилтын шаардлага хангахгүй төгсгөлийн төхөөрөмжийг холбох, түүнийг ашиглан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

4.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчээс интернэтийн үйлчилгээтэй холбоотой гомдол, санал хүлээж авах, шийдвэрлэх журамтай байх ба гомдол маргааныг үл ялгаварлах, шуурхай байдлаар шийдвэрлэнэ.

¹¹ IPv4 and IPv6 Dual Stack

¹² NAT

¹³ IANA - Internet Assigned Numbers Authority

¹⁴ Үүрэн холбооны 3G, 4G/LTE технологи, утасгүй сүлжээний WiFi технологи

4.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийг өөрийн үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөмжөөр хангана.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

5.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн чанар, урсгалын хурдыг хянахад зориулж интернэтийн чанарыг шалгах арга зам, зөвлөмжийг өөрийн цахим хуудсанд байршуулна.

5.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байршиж байгаа контентийн урсгал (цахим хуудас, цахим шуудан, файл хостинг, клауд, видео стриминг, төрийн үйлчилгээ гэх мэт хэрэглээ)-д хурдны хязгаарлалтгүй холбох бөгөөд гадаад урсгалд хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасан хурдаар холбоно.

5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн гэрээлсэн хурдны хэмжээ оргил ачааллын цагаар хамгийн багадаа 75 хувиас багагүй байхаар ачааллын хэмжээг тооцоолж, зохион байгуулна. Үйлчилгээний чанарт байнгын хяналт тавих боломжоор Зохицуулах хороог хангана.

5.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Улаанбаатар хотод 50 Мбит/сек, аймгийн төвд 10 Мбит/сек ба түүнээс дээш гадаад интернэтийн урсгалыг түрээсэлнэ. (Сум суурин газарт дээрх нөхцөл хамаарахгүй)

5.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь "Интернэтийн чанарт тавих шаардлага" MNS 6966:2026 Монгол Улсын стандартыг мөрдөнө.

5.8. Зохицуулах хороо нь интернэтийн үйлчилгээний чанарын шаардлагын хэрэгжилтийг хараат бус хэмжилт хийх, мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн тайланд үндэслэн дүн шинжилгээ хийх замаар үнэлнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөг мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна¹⁵.

6.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үед хэрэглэгчийг шилжүүлэх төлөвлөгөөтэй байна.

--- оОо ---

¹⁵ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11, 27-р зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 23-р зүйл